



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 23 өдөр

Дугаар А/447

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Агаарын тухай хуулийн 8 дугаар зүйл 8.1.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны ээлжит XVI хуралдааны 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Агаар орчны бохирдлыг бууруулах ажлын хүрээнд зохион байгуулагдах сургалтын гарын авлага материал болох “Нэг удаа дулаал, зуун жил хэмнэ” сэтгүүл худалдан авах зардалд 2.000.000 (Хоёр сая) төгрөгийг зарцуулсугай.
2. Дээрх зардлын 2.000.000 (Хоёр сая) төгрөгийг Засаг дарга дансны “Агаарын бохирдол бууруулах зардал”-аас гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Батбилгүүн)-д зөвшөөрсүгэй.
3. Агаар орчны бохирдлыг бууруулах сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулж, тайлагнан ажиллахыг аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар (П.Мөнхжаргал)-т даалгасугай.
4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар) -д даалгасугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ

